Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2025 оны 03.. сарын ..19.-ны өдөр хүлээн авсан.

# ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД, ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2025 оны 03 дугаар сарын 07-ны өдөр | Дугаар А/68 А/62 | Улаанбаатар хот

Тушаалд нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 6, Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 11, Засгийн газрын 2024 оны "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа иргэнд олгох тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох, тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 247 дугаар тогтоол, Засгийн газрын 2021 оны 173 дугаар тогтоолоор батлагдсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрэм"-ийн 5.11-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2021 оны "Жагсаалт, шалгуур үзүүлэлт, маягт шинэчлэн батлах тухай" А/807, А/216 тоот хамтарсан тушаалын 1 дэх заалтад "... дөрөвдүгээр," гэсний дараа "Байнгын асаргаа шаардлагатай, хүнд хэлбэрийн 0-16 насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг тодорхойлох өвчин, гэмтлийн жагсаалт, шалгуур "-ыг тавдугаар" гэж нэмсүгэй.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД Т.МӨНХСАЙХАН

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД Л.ЭНХ-АМГАЛАН

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ
Бүртгэлийн дугаар ... 16 ...
ХУУЛБАР ҮНЭН
........................
( Албан тушаалын нэр)

Эрүүл мэндийн сайд, Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 05 сарын 07 өдрийн А/63, А/62 дугаар хамтарсан тушаалын хавсралт

# БАЙНГЫН АСАРГАА ШААРДЛАГАТАЙ 0-16 НАСНЫ ХҮҮХДИЙН ХҮНД ХЭЛБЭРИЙН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙГ ТОДОРХОЙЛОХ ӨВЧИН ГЭМТЛИЙН ЖАГСААЛТ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

| № | Өвчний бүлэг | Өвчний нэр, үе шат | Өвчний олон улсын код. (Өвчний олон улсын ангилал ICD-10-ын дагуу) | Өвчний шинж тэмдэг , Шалгуур үзүүлэлт |
|---|---|---|---|---|
| 1 | Хүүхдийн тархины саа, саажилт | Дөрвөн мөчдийн саа | G80.0 | Ерөнхий хөдөлгөөний үйлийг ангилах үнэлгээний IV-V түвшинг багтаана (GMFCS).<br>- Бие даан хөдлөх чадвар эрс хязгаарлагдсан.<br>- Хөдөлгөөний үйл ажиллагаа бүх талаар суларсан.<br>- Нэмэлт төхөөрөмжтэй байсан ч бие даан сууж, зогсож чадахгүй (хэвтрийн) |
| 2 | | Хоёр мөчдийн чангарал бүхий саа | G80.1 | Ерөнхий хөдөлгөөний үйлийг ангилах үнэлгээний IV түвшинг багтаана (GMFCS).<br>- Туслах төхөөрөмжтэй байсан ч алхах чадвар эрс хязгаарлагддаг. Бие даан хөдлөх чадвар хязгаарлагдсан (зөвхөн сууна)<br>- Ихэнхдээ тэргэнцэр ашигладаг, өөрөө цахилгаан тэргэнцрийг хөдөлгөж чаддаг байж болно. |
| 3 | | Хүүхдийн тал саажилт эсвэл G40+F07 хавсарсан үед | G80.2 | Ерөнхий хөдөлгөөний үйлийг ангилах үнэлгээний V түвшинг багтаана (GMFCS).<br>өдөлгөөний туслах төхөөрөмжээр дотор, гадаа тэгш гадаргуу дээр алхаж чадна.<br>ашлага ашиглан шатаар өгсөх боломжтой.<br>ол зайд, тэгш бус гадаргуу дээр хөдлөхөд тэргэнцэр шаардлагатай |

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ
Бүртгэлийн дугаар . 16 . . . .
ХУУЛБАР ҮНЭН
. . . . . . . . ТЗҮГ . . . . . . . .
( Албан тушаалын нэр)

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | Ерөнхий хөдөлгөөний үйлийг ангиалах үнэлгээний III түвшинг багтаана. (GMFCS).<br>отор, гадаа алхаж явна,<br>атаар алхахдаа хашлагатай шатаар алхана.<br>эгш бус гадаргуу, налуу замаар явах, олны дунд хөдлөхөд хүндрэлтэй байдаг<br>үйх, эсвэл үсрэхэд бэрхшээл тод илэрнэ. |
| 4 | | Хөдөлгөөн гажих хөшүүн саа (дискинетик) | G80.3 | Ерөнхий хөдөлгөөний үйлийг ангилах үнэлгээний V түвшинг багтаана<br>➢ Бие даан хөдлөх чадвар эрс хязгаарлагдсан.<br>➢ Хөдөлгөөний үйл ажиллагаа бүх талаар суларсан.<br>➢ Нэмэлт төхөөрөмжтэй байсан ч бие даан сууж, зогсож чадахгүй (хэвтрийн)<br>Ерөнхий хөдөлгөөний үйлийг ангилах үнэлгээний IV түвшинг багтаана<br>➢ Туслах төхөөрөмжтэй байсан ч алхах чадвар эрс хязгаарлагддаг. Бие даан хөдлөх чадвар хязгаарлагдсан (зөвхөн сууна)<br>Ихэнхдээ тэргэнцэр ашигладаг, өөрөө цахилгаан тэргэнцрийг хөдөлгөж чаддаг байж болно. |
| 5 | | Тэнцвэргүйдэх саа | G80.4 | Ерөнхий хөдөлгөөний үйлийг ангилах үнэлгээний II түвшинг багтаана<br>➢ Хөдөлгөөний туслах төхөөрөмжөөр дотор, гадаа тэгш гадаргуу дээр алхаж чадна.<br>➢ Хашлага ашиглан шатаар өгсөх боломжтой.<br>➢ Хол зайд, тэгш бус гадаргуу дээр хөдлөхөд тэргэнцэр шаардлагатай.<br>Ерөнхий хөдөлгөөний үйлийг ангилах үнэлгээний III түвшинг багтаана<br>➢ Дотор, гадаа алхаж явна, шатаар алхахдаа хашлагатай шатаар алхана<br>➢ Тэгш бус гадаргуу, налуу замаар явах, олны дунд хөдлөхөд хүндрэлтэй байдаг.<br>Гүйх, эсвэл үсрэхэд бэрхшээл тод илэрнэ. |

Бүртгэлийн дугаар ..../6....
ХУУЛБАР ҮНЭН
ТВУГ
(Албан тушаалын нэр)

| | | | | |
|---|---|---|---|---|
| 6 | | Тархины бусад саа (холимог хэвшинж) | G80.8 | Ерөнхий хөдөлгөөний үйлийг ангилах үнэлгээний V түвшинг багтаана<br>➢ Бие даан хөдлөх чадвар эрс хязгаарлагдсан.<br>➢ Хөдөлгөөний үйл ажиллагаа бүх талаар суларсан.<br>➢ Нэмэлт төхөөрөмжтэй байсан ч бие даан сууж, зогсож чадахгүй (хэвтрийн)<br>Ерөнхий хөдөлгөөний үйлийг ангилах үнэлгээний IV түвшинг багтаана<br>➢ Туслах төхөөрөмжтэй байсан ч алхах чадвар эрс хязгаарлагддаг. Бие даан хөдлөх чадвар хязгаарлагдсан (зөвхөн сууна)<br>Ихэнхдээ тэргэнцэр ашигладаг, өөрөө цахилгаан тэргэнцрийг хөдөлгөж чаддаг байж болно. |
| 7 | | Тархины саа, тодорхойгүй | G80.9 | Булчин сулрах хэлбэрийн тархины саа хамарна.<br>Ерөнхий хөдөлгөөний үйлийг ангилах үнэлгээний V түвшинг багтаана<br>➢ Бие даан хөдлөх чадвар эрс хязгаарлагдсан.<br>➢ Хөдөлгөөний үйл ажиллагаа бүх талаар суларсан.<br>➢ Нэмэлт төхөөрөмжтэй байсан ч бие даан сууж, зогсож чадахгүй (хэвтрийн)<br>Ерөнхий хөдөлгөөний үйлийг ангилах үнэлгээний IV түвшинг багтаана<br>➢ Туслах төхөөрөмжтэй байсан ч алхах чадвар эрс хязгаарлагддаг. Бие даан хөдлөх чадвар хязгаарлагдсан (зөвхөн сууна)<br>➢ Ихэнхдээ тэргэнцэр ашигладаг, өөрөө цахилгаан тэргэнцрийг хөдөлгөж чаддаг байж болно. |
| 8 | | G80 ба F71-F73 оюуны бэрхшээл хавсарсан | G80 ба F71-F73 | Ерөнхий хөдөлгөөний үйлийг ангилах үнэлгээний V түвшинг багтаана<br>- Бие даан хөдлөх чадвар эрс хязгаарлагдсан<br>- Хөдөлгөөний үйл ажиллагаа бүх талаар суларсан<br>- Нэмэлт төхөөрөмжтэй байсан ч бие даан сууж, зогсож чадахгүй, (хэвтрийн) |
| 9 | Хорт хавдрууд | Нейробластома | C47 | Мэс засал, хими эмчилгээний 6 сар, барих эмчилгээний 1 жил буюу 12 сар |
| 10 | | Ретинобластома | C69.2 | |

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ
ХУУЛБАР ҮНЭН
( Албан тушаалын нэр)

| | | | | |
|---|---|---|---|---|
| 11 | | Зөөлөн эдийн хавдар | C49.9 | |
| 12 | | Ясны хавдар | C41 | |
| 13 | | Юингийн хорт хавдар | C40 | |
| 14 | | Тархины хорт хавдар | C71 | |
| 15 | | Элэгний хорт хавдар | C22.2 | |
| 16 | | Бөөрний хорт хавдар | C64 | |
| 17 | | Үр хөврөлийн эсийн гаралтай хорт хавдар | C62.9, C56 | |
| 18 | | Өнчин тархины аденом | C75 | |
| 19 | | Гистоцитоз Х - нэг бөөмт эсийн хорт хавдар | D76.3 | |
| 20 | Оюуны хомсдол | Оюуны хүнд ба гүнзгий хомсдол (IQ 34 хүртэл) | F72<br>F73 | Маш гүнзгий оюуны хомсдолтой Оюуны коэффициент (IQ) ойролцоогоор 34-оос бага (насанд хүрэгчдийн хувьд оюуны хөгжил нь 3-6 наснаас доош настай хүүхдийн төвшинд байна гэсэн үг). Бие дааж өөрийгөө авч явах, бусадтай харилцах, хөдөлж явах чадвар туйлын дорой. |
| 21 | Аутизмын хүрээний эмгэгүүд | Аутизмийн хүрээний эмгэг үүнээс зөвхөн 3 -р түвшин буюу сэтгэцийн DSM 5 оноштой. | F84.0<br>F84.2 ба Реттийн хам шинж | a.Нийгэмшихүй, харилцаа хэл яриа маш хязгаарлагдмал болон огт байхгүй, харилцааны чадваргүй тул сэтгэл санаа, бие махбодын үйлдлийн чадвар маш их доройтсон, нийгмийн харилцаанд орж чадахгүй, бусад хүн харилцахад хариу үйлдэл үзүүлэхгүй<br>b. Үйлдэл нь давтагдмал ба хязгаарлагдмал<br>Үйлдэл нь уян хатан биш, гэнэтийн өөрчлөлтөд маш бухимддаг. Хүүхэд 1-2 үйлдлийг байнга давтах ба олон янзын үйлдэл хийх чадваргүй, зарим хүүхдэд өөрийгөө гэмтээх болон түрэмгий хандлага илэрч болно.<br>Энэ нь хөгжлийн ихэнх айд илт бэрхшээлийг үүсгэнэ. |
| 22 | Сохрол | Хоёр нүд сохор | H54 | 0-16 насны хүүхдүүдэд хоёр нүд хараагүй байх. |

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ
Бүртгэлийн дугаар ...16...
ХУУЛБАР ҮНЭН
( Албан тушаал...

| | | | | |
|---|---|---|---|---|
| 23 | | Эмэнд тэсвэртэй эпилепси /комплекс таталт бүхий эпилепсийн хам шинж/ | G40.2<br>G40.4<br>G40.5 | Тухайн эпилепсийн хэлбэрт зохистой хоёроос доошгүй эмийн эмчилгээнд эпилепсийн уналт таталтын давтамж багасаагүй, үр дүнгүй байх тохиолдолд "эмэнд тэсвэртэй эпилепси" хэмээх оношийг тавина. Эмэнд тэсвэртэй эпилепсийн уналт таталтын давтамж өндөр байна (ухамсарт ухааны алдагдал бүхий уналтууд сард 4-өөс дээш удаа, ухамсарт ухаан алдахгүй жижиг уналтууд өдөр бүр). |
| 24 | | Хавсарсан эмгэг: Тархины өвчин, гэмтэл, үйл ажиллагааны хямралын шалтгаант сэтгэций эмгэг тодорхойгүй | G40.2,<br>G40.4,<br>G40.5 ба<br>F07 | Тухайн эпилепсийн хэлбэрт зохистой хоёроос доошгүй эмийн эмчилгээнд эпилепсийн уналт таталтын давтамж багасаагүй, үр дүнгүй байх тохиолдолд "эмэнд тэсвэртэй эпилепси" хэмээх оношийг тавина. Эмэнд тэсвэртэй эпилепсийн уналт таталтын давтамж өндөр байна (ухамсарт ухааны алдагдал бүхий уналтууд сард 4-өөс дээш удаа, ухамсарт ухаан алдахгүй жижиг уналтууд өдөр бүр).<br>Дараах шинжийг агуулсан тархины хүнд эмгэгийг эпилепсийн энцефалопати гэж тодорхойлно:<br>1) тархины цахилгаан бичлэгт байнга илрэх пароксизм идэвхжил<br>2) олон хэлбэртэй уналт таталттай, эмэнд тэсвэртэй<br>3) танин мэдэхүйн хөгжлийн хоцрогдол, төрх үйлийн ба мэдрэлийн голомтот өөрчлөлттэй<br>4) зарим тохиолдолд эрт үхэлтэй. |
| 25 | Уналт таталт /эпилепси/ | Нийлмэл-хэсэгчилсэн уналт бүхий байршлын хамааралт (хэсэгчилсэн) шинж тэмдгийн эпилепси, эпилепсийн хам шинж | G40.2 | - Ухамсарт ухаан өөрчлөгдөх уналтын дайрал<br>- Хоёрдогч ерөнхий уналт болж хувирах нийлмэл хэсэгчилсэн уналт |
| 26 | | Эпилепсийн онцгой хам шинж | G40.5 | - миоклоник таталт<br>-миоклоник-астатик уналт<br>- Нялхсын таталт<br>- Ленокс-Гасто хамшинж<br>- Мэхийх таталт (салаам)<br>- Эрт үеийн миоклоник энцефалопати<br>- Вестийн хамшинж |
| 27 | | Тархи, нугасны цочмог | G81,<br>G82, | Менингоэнцефалит, энцефалит, миелит, энцефаломиелит, тархи |

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ
...ийн дугаар 16
ХУУЛБАР ҮНЭН
739
(Албан тушаалын нэр)
Монгхаа

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | эмгэгийн дараах үлдэц болох тал биеийн саажилт, дөрвөлсаа, хөлийн хос саа, тэнцвэргүйдэл, хараагүйдэл, сонсголгүйдэл, аарцгийн эрхтэний үйл ажиллагааны алдагдал ба танин мэдэхүйн хөгжлийн саатал | G83, ба R32 хавсрах | нугасны хүнд гэмтэл, хавдар, тархи усжилт, харвалт зэрэг бүх төрлийн тархи нугасны гэмтлийн дараах үлдэц байдал багтана.<br>Ерөнхий хөдөлгөөний үйлийг ангилах үнэлгээний IV-V түвшинг багтаана. |
| 28 | | Сул саажилт, булчингийн хатангирал бүхий мэдрэл-булчингийн даамжрах эмгэг | G12.0<br>G12.1<br>G71<br>G60 | Хүүхэд наснаас эхлэн даамжрах бүх төрлийн миодистрофи, миотонийн дистрофи, гар хөлийн хөдөлгөөнд илт нөлөөлсөн удмын нейропати багтана.<br>Ерөнхий хөдөлгөөний үйлийг ангилах үнэлгээний III-V түвшинг багтаана |
| 29 | | Үрэвслийн шалтгаант хүнд хэлбэрийн полирадикулоневритийн үлдэц байдал | G61 | Хүнд хэлбэрийн полирадукулоневритийн дараа үлдэх сул саажилт, бие даах чадвар алдагдсан байх.<br>Ерөнхий хөдөлгөөний үйлийг ангилах үнэлгээний III-V түвшинг багтаана |
| 30 | | Удмын бага тархины тэнцвэргүйдэл | G11 | Хүүхэд наснаас эхлэх бага тархины тэнцвэргүйдлийн эмгэг нь ховор тохиолдох, генийн эмгэгтэй холбоотой, аажим даамжрах өвчний тоонд багтана.<br>Тархины олдмол эмгэгийн дараах үлдэц болох тэнцвэргүйдэл үүнд хамаарахгүй. |

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ
Бүртгэлийн дугаар 16
ХУУЛБАР ҮНЭН
ТЗУГ
(Албан тушаалын нэр)

| | | | | |
|---|---|---|---|---|
| 31 | | Мэдрэлийн тогтолцооны гаж хөгжилтэй холбоотой танин мэдэхүйн өөрчлөлт/хөгжлийн хоцрогдол, хөдөлгөөний эвслийн алдагдал, мөчдийн саажилт, хэл залгиурын саажилт, аарцгийн эрхтэний үйл ажиллагааны алдагдал | Q01<br>Q05<br>Q07.0<br>Q03.1<br>Q75.0<br>Q75.8<br>Q75.8<br>Q87.0-Q87.8<br>Q90-Q99 | Үүнд микроцефали, менингоцеле, менингоэнцефало-целе, спина бифида, краниосиностоз, базилар имресси, атланто-окципитал үений гажиг, Arnold-Chiari гажиг, Dandy-Walker хамшинж г.м. гаж хөгжлийн гажиг бүхий эмгэгүүд багтана. Эдгээрээс гадна Дауны хамшинж, Pradera-Willi, Klinefelter, Turner, Martin-Bell, Rett хамшинж гэх мэт хромосомын ба генийн гажиг бүхий эмгэг багтана.<br>Өдөр тутмын чадварыг үндэслэнэ. |
| 32 | Биеийн гадаргуу дахь түлэгдэлт | Түлэгдэлтийн 3 дугаар зэргээс дээш, биеийн гадаргуугийн 50% -с дээш талбай түлэгдэж арьс үхжиж сорвижсон 2 ба түүнээс дээш том үений татагдаж наалдсан сорви бүхий үений өөрчлөлттэй бүх төрлийн түлэгдэлт | T20-T32 | Батлагдсан эмнэлзүйн онош, эмчилгээний явцыг харгалзан шийдвэрлэнэ. |
| 33 | Төрөлхийн гаж хөгжил | Төрөлхийн доод мөчгүй | Q72.0 | Батлагдсан эмнэлзүйн онош, эмчилгээний үе шатыг харгалзан шийдвэрлэнэ. |
| 34 | | Төрөлхийн шилбэ ба тавхайгүй | Q72.2 | |

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ
Бүртгэлийн дугаар ...16....
ХУУЛБАР ҮНЭН
.......ТЗҮГ.......
( Албан тушаалын нэр)

| | | | | |
|---|---|---|---|---|
| 35 | | Тархины төрөлхийн том энцефалоцеле | Q01 | |
| 36 | | Нугасны төрөлхийн хүнд хэлбэрийн ивэрхий | Q06 | |
| 37 | | Тархины төрөлхийн хүнд хэлбэрийн усжилт | Q03.8-Q03.9 | |
| 38 | | 2 чихний төрөлхийн дутуу хөгжил | Q16 ба F84.0 | Хоёр талын гадна дунд чихний төрөлхийн гажигтай 3-4 зэргийн сонсгол бууралттай. Аутизмтай |
| 39 | | 2 чихний дуу хүлээн авах хэлбэрийн дүлий | H90.3 H90.5 | Батлагдсан эмнэлзүйн онош, эмчилгээний үе шатыг харгалзан шийдвэрлэнэ. |
| 40 | | Мөгөөрсөн хоолойд гуурс тавих эмчилгээ хийгдсэн | J38 | Дуу нөхөн сэргээгдэхгүй, мөгөөрсөн хоолойг нөхөх боломжгүй нь тогтоогдсон. |
| 41 | | Дауны хам шинж болон бусад хромосомын гажуудалтай, оюуны бэрхшээл хавсарсан | Q 90.9 - Q 99 ба F71-73 хавсрах Q90.9- Q 99 ба Q24.9 хавсрах | Батлагдсан эмнэлзүйн онош, эмчилгээний үе шатыг харгалзан шийдвэрлэнэ. |
| 42 | Бусад өвчин эмгэг | | | Иргэний гаргасан өргөдлийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ. |

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ
Бүртгэлийн дугаар ....16....
ХУУЛБАР ҮНЭН
....ТБУТ....
( Албан тушаалын нэр)